

V. Аяны тэмдэглэл, домог, хууч яриа

ШАНДЫН ШАР ТАЛ МИНУ

(Аян замын тэмдэглэл)

Ж.Болдбаатар (МУИС)
Д.Баяр (ШУА, Археологийн хүрээлэн)

1. Учирлал

V сарын дундуур МУИС-ийн НШУС-ийн оюутны бие даах төвд Түүхийн шинжлэх ухаанаар доктор (Ph.D) хамгаалуулахаар зөвлөлийн хуралдаан эхлэх гэж байтал ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор Ч.Дашдаваа:

- Манай хүрээлэнгийн урилгаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шулуун Хөх хошууны намын хороо, Засгийн ордны төлөөлөгчид манай оронд зочилсон. Тэд монголын түүхчдийн төлөөлөгчдийг өөрийнхөө хошуунд айлчлахыг урьсан гэв. Бид:

- Ямар зорилготой Монголын түүхчдийн төлөөлөгчдийг урьж байгаа юм бол... Дашдаваа захирал:

- Хубилай хааны Дээд нийслэл-Шанд балгасыг дэлхийн соёлын өвд бүртгүүлэх гэж байгаа гэнэ. Энэ тухай монголын түүхчид мэдэж, бас боломжоороо дэмжлэг үзүүлбэл сайн гэсэн. Монголын түүхчдийн төлөөлөгчдийг урьсан учир манай хүрээлэнгээс Дундад зууны тасгийн эрхлэгч, доктор А.Пунсаг бид хоёр, Археологийн хүрээлэнгээс доктор (Sc.D) профессор Д.Баяр, МУИС-ийн академич Ж.Болдбаатар нарыг оруулбал зүгээр гэж бодож байна гэлээ.

Бид ч урилгыг талархан хүлээн авсан юм. Профессор Д.Баяр бид хоёр энэ тухай гарсан ном зохиол сөхөн үзэж, өмнө нь Шандад аялсан академич Ч.Далай, Д.Төмөртогоо, МУИС-ийн зочин профессор, Германы монголч эрдэмтэн Удо Баркманн нартай уулзаж, аялалынхаа үед юу үзэх, анхаарах талаар зөвлөгөө авлаа. Олон жил Монголын түүх заахдаа Хубилай хааны дээд нийслэл-Шанду, Шандын шар талын тухай олон ч удаа дурссан даа. Одоо л нүдээрээ үзэх боломж олдох нь. "Зуу сонсохоор, нэг удаа үз" гэдэг дээ.

2. Аян замын эхэн

Хүсэн хүлээсэн аялал эхэллээ. Бид дөрөв дөрөв өмнө зүг хүлгийн жолоог залан галт тэргэнд тухлан суулаа. Ийнхүү 2006 оны VII сарын 2-ны өдрийн 20 цагт Улаанбаатараас галт тэргээр гарч явсаар VII сарын 3-ны өглөө Сайншандыг дайран БНХАУ-ын хилийн хот-Эрээнд ирлээ. Эрээн хотод биднийг Содгэрэл, Сэцэн хэмээх хоёр хүн угтан авсан ба тэндээсээ Содгэрэлийн машинаар Шулуун Хөх хошууны нутгийг зорин зүүн зүг хөдлөв. Явах зам шулуун дардан бөгөөд цагт 110-120 км-ийн хурдтай давхиж, Зүүн Сөнөд хошууны нутаг-Тамч хэмээх уудам их талыг туулан явлаа. Нутгийн төрх манай Дорноговь аймагтай тун төстэй, айл хунар харагдахгүй, зэлүүд уудам нутаг бөгөөд гандуу, өвс ургамалын гарц тааруу, сүүлийн хэдэн жил зуншлага тааруу байгаа гэнэ. Уул толгод харагдахгүй, Мэнэнгийн тал шиг нүд алдам, өргөн уудам нутаг юм.

Ийнхүү зүүн зүгийг барин давхисаар Зүүн Сөнид хошууны төв Мандалт балгасыг дайран Авга хошууны нутагт орж ирвэл байгал орчны байдал ихэд өөр болж, өвс ургамал жигдэрсэн өнтэй сайхан байгал, цаг уур угтлаа. Эндэх газар нутаг түрүүчийн бидний дайран өнгөрсөн Сөнөд хошууны говь цөлөрхөг хөрснөөс ихээхэн ялгаатай, замын хажуугаар таана хөмөл жигдрэн ургажээ. Таана хөмөлийн үнэр хамар цоргиж, ногоорон дуниартах тал нутаг сэтгэл гэгэлзүүлнэ. Энэ их талыг хөвөөлөн тэгш тайрсан мэт хавтгай оройтой намхавтар уулс тогтсон нь манай Дарьганга нутагтай их л төстэй, ер нь тэрхүү галт уулсын бүсийн үргэлжлэл бололтой. Чингис хаан хилэгнэн энэ уулсын оройг дэвсэлсэн буюу сэлмээрээ цавчиж тайрсан гэж домог болгон хэлэлцдэг гэнэ. Бидний эцэг, өвгөд, эзэн Богд Чингис хаан маань энэ тэнүүн тал нутгаар эвэр нумаа эвшээлгэж, илд бамбайгаа агсаж, эр цэргээ дагуулан, ид хаваа үзүүлж явсан даа хэмээх сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө. Бидний аялсан эдгээр нутаг бүгд Өвөр монголын малжих орны нутаг бөгөөд тариа тарьж, атар хагалсан зүйл үгүй, бүгдийг малын билчээр болгон ашигладаг бөгөөд замын хажуугаар тор татан хашаалсан нь газар нутгийг малчдад хувьчлан өгч эзэмшүүлсний зааг хязгаарын тэмдэг болой. Айл хунар цөөн, ихэнх малчин айл цөм байшин барьж суурьшсан ба хааяа нэг гэр барьсан харагдах нь чамгүй чинээлэг малчид байшингийнхаа хажууд гэр барьж монгол ахуй байдлаа хадгалахыг эрмэлзэж буйг гэрчилнэ. Мал сүрэг хариулсан хүн ч тааралдаж, зарим газар монгол дээлээ өмссөн хүн ч харагдаж байлаа.

Удалгүй нэгэн том хот руу орж ирэв. Орчин үеийн шаггүй том хот байлаа. Энэ нь Шилийн гол аймгийн төв-Шилийн хот юм байна. Тус хотыг өнгөрч 100 орчим км давхиж, Хүйтэн шилийг дамжаад Хулан даагын элс хэмээх үргэлжилсэн их элс манхан бүхий газарт ирэв. Энэ нь дан ганц нүцгэн элс бус, баян бүрд аж. Учир нь энд тэндгүй хайлаас, улиас модон төгөл харагдах бөгөөд ихэнхи мод бодит элсний нүүдлээс сэргийлэн элс манхны хажуу бэлээр бут сөөг эгнүүлэн тарьж бэхэлсэн байх ба зарим газраар багавтар хэрэм далан барьж хамгаалсан байна. Мод тарих ажлыг нам, засгаас ихээр хөхиүлэн дэмжиж, нэг мод суулгахад 5 юан олгох ба цаашид тарьсан модоо арчилж сайн ургуулсан тохиолдолд жил жилд шагнал урамшил нэмэгддэг байна. Таван жилийн турш мод бут амжилттай тарьж ургуулсан бол томоохон шагнал олгодог гэнэ. Замын хажуугаар ийнхүү мод тарьж ургуулах нь Хубилай хааны үүсгэл санаачлагаас үүдэлтэй аж. Ийнхүү Монголчууд дан ганц эвдэн бусниулагч биш бүтээн босгогчид, шинийг сэдэгчид байлаа. Бидний монголчууд тэрхүү уламжлалаа шинэ нөхцөлд ялангуяа хуурайсаж, цөлжиж буй үед шинэ агуулгаар сэргээх хэрэгтэй юм.

Хадан хошуу хэмээх газраас зам салахад замын баруун талд Хавирга хэмээх газарт хятад хүмүүс төвлөрч, тариа ногоо тарьж суусан суурин газар оршино. Бид нэг хэсэг энхэл донхол ихтэй шороон замаар аялав. Ийнхүү явсаар харуй бүрий болоход Шулуун Хөх хошууны төв, урьд нь Дунд хот нэртэй байсан, одоо Шанд балгас гэх болсон хотод ирвэл хошууны намын хорооны дарга Сүй Жан Гүй, орлогч дарга Сэцэнчимэг, Хошуу даргын соёл хариуцсан орлогч Хас, намын хорооны Соёл хариуцсан орлогч дарга Төмөрөө, хошууны утга урлагийн холбооны тэргүүлэгч Оюундалай, соёл урлаг, радио телевиз, тамирын товчооны дарга Мөнхбаатар зэрэг хүмүүс халуун дотноор угтан авч, "Шулуун Хөх хошууны Юаны Дээд нийслэлийн зуслангийн том буудал" хэмээх буурчийн газар байрлууллаа. Оройн зоог барьж, ерөөл бэлгэдлийн үгс хэлэлцэв.

3. Түүхт Долоннуур хотноо

7 дугаар сарын 4-ний өдөр Шулуун Хөхийн төвөөс гарч Шандын шар талыг өнгөрөн, Долооннуур буюу манайхны хэлж заншсанаар Долнуурт ирэв. Шулуун хөх хошууны нутаг орчим хужир, шүү бүхий долоон нуур байдаг бөгөөд тэдгээрээс хамгийн гол хэсэг түүхт газар нь энэ учир Долоннуур нэр авчээ. Анх хужир шүү худалддаг суурин бий болж, энэхүү хот эх сууриа тавьсан гэнэ. Энд бид түүхийн

дурсгалт Хөх сүм, Шар сүмийг үзэв. Эл газарт, тухайлбал энэхүү Хөх сүмд 1691 онд Ар Халхын 57 хошуу, Өврийн 49 хошууны ноёд чуулж, Халх Монгол Манж Дайчин улсад дагаж орох хэргийг хэлэлцсэн бөгөөд өөрөөр хэлбэл, халх монголчууд эрх чөлөө, туурга тусгаар байдлаа алдсан буюу дагаар орсныг ёсчлон баталсан ажээ. Эхлээд Долоннуурыг Манжийн хаан нэг өргөө ордноо болгож босгосон байна. Хаан аажимдаа тэр болгон морилж ирэхээ больсон учир сүүлдээ сүм хийдийн эзэмшилд шилжүүлжээ. Хөх сүмд Манжийн Энх Амгалан, Найралт Төв хаад морилон ирж байсан, Халхын Өндөр гэгээн Занабазар ирж сууж байсан, түүнчлэн эндээс 13 хутагт хувилгаад төрж гарсан гэх ба Монгол даяар нэн их алдартай Жанжаа Хутагт мөн эндээс тодрон гарсан түүхтэй ажээ. Хожим Хятадын хувьсгалын үед томоохон лам нар нь Тайваньд хальж гарсан гэнэ. Эдүгээ эдгээр сүмийг үзмэр музей байдалтай болгосноос гадна бас лам нар ч хурал номоо хурдаг. Энх Амгалан, Найралт Төв хаадын зурмал хөрөг, эндхийн хутагт хувилгаадын гэрэл зураг, уг сүмийн үе үеийн түүхээс харуулсан зургууд, түүхэн биет зарим үзмэр энд байх юм.

Шар сүм нь үүнээсээ холгүй, мөн хотын дотор байх ба таван давхар модон тулгууртай барилга нь нэн өвөрмөц онцлогтой бөгөөд харин зарим хэсэгт айл байрласан байх ба сүм хийдийн барилга нь нилээд муудан эвдэрч, доторхи ханын зураг, бичээс тэргүүтэн нь элэгдэж өгөршсөн байдалтай. Ирэх жилээс энэ сүмийн барилгыг чөлөөлж суллан, түүх, соёлын дурсгалын хамгаалалтад авахаар төлөвлөж байгаа юм байна.

Долоннуур хот ур ухаан бүхий урчуудаараа алдартай, тэдний бүтээсэн бурхны хөрөг баримлууд Ар газарт ихээхэн дэлгэрэн нэвтэрсэн, ер нь нийт монголчуудын бурхан шашны эдлэл хэрэглэлийн хэрэгцээг эндээс голлон хангаж байжээ. Энэ нь шашны төдийгүй, худалдаа, гар урлалын томоохон төв болж байснаараа ихэд нэрд гарсан бөгөөд зөвхөн бурханы хөрөг төдийгүй эмээл, булигаар, жийжүү дөрөө зэргийг өргөн үйлдвэрлэдэг байжээ. Биднийг Долоннуур хотын удирдлага хүлээж авч уулзан дайлж цайллаа.

4. Хубилай хааны Дээд нийслэл-Шанд балгаснаа

Тэндээс хөдлөн явж, Юан улсын Дээд нийслэл, их хаадын зуслан Шанд балгасанд ирэв. Бидний энэ аялалд Шулуун Хөх хошууны ахмад сэхээтэн, орон нутгийнхаа түүхийг сонирхон судлагч, Шанд балгасын талаар анхны судалгааны

ном бичсэн монгол хүн болох Дуншиг багш хамт явж бүх зүйлсийн түүхэн эх үндсийг тайлбарлан таниулж байсан нь бидэнд тун таатай байлаа.

Шанд балгасыг Хубилай хаан 1256-1260 онд байгуулжээ. Хот байгуулах газар нутгийг тун оновчтой зөв сонгож авсан нь шууд л мэдрэгдэж байв. Энд зуны халуунд сэрүүн шившээ салхи сэрчигнэж, ус ургамал жигдэрсэн сэтгэл татам газар бөгөөд монголчуудын уугуул нутгийн өмнөд зах хязгаар юм. Ийм сайхан байгал, цаг уурын тааламжтай сайхан нөхцөл бүрдсэнээс шалтгаалан, монгол хаад хэдийгээр Бээжин орчимд Дайду буюу Ханбалык хэмээх их нийслэлийг байгуулсан ч зуны улиралд Бээжингийн халуунаас зугадан Шандын сэрүүн ордонд ирж зусдаг уламжлалтай байжээ. Энэ нутгийг биеэр үзэж, анхилам сайхан агаараар нь амьсгалхын цагт ийм бишрэм сайхан нутаг юугаа алдсан Тогоонтөмөр хааны гэмшлийн шүлэг өөрийн эрхгүй санаанд бууна.

Эртний хаадын зуслан

Шандын шар тал минь !

Эрхлэн жаргах сэрүүн сайхан

Шанд Хийвэн балгас минь !

Эрдэнийн зүйлээр чимэглэсэн

Найман талт цагаан суварга минь !

Шанд балгасын өмнүүр Шандын гол мяралзан урсана. Араар нь Их Хурх, Бага Хурхын уул олон он жилийн түүх цадигийг аялгуулан хүүрнэх монгол өвгөд мэт дүнхийнэ. Энд Хийвэн галын нэрээр нэршсэн Хийвэн орд гэж байсан гэнэ. Урдуур нь Хийвэн гол Шандтай гол нийлэн урсана. Долнуураас дээшилж, Лон Хэ гол болдог. Энэ нутаг монголчуудын нутаг боловч бүр Киданы үеэс уламжилсан ийм нэртэй байсан юм байна.

Хотын хана хэрмийн хэмжээ хааш хаашаагаа 2200 м. Чанх ертөнцийн зүгээр байрласан, энэ нь орчин үеийн хэмжилтээс ердөө л ганц хэмээр зөрдөг гэнэ. Бээжин дэх Дайду хот ч мөн яг ийм байрлалтай бүлгээ.

Шанд балгас нь гадар хот, дотор хотоос бүрдэх ба өмнөд гол хаалгыг малтан ил гаргаж, зарим талаар сэргээн засварласан байна. Ерөнхийдээ хадгалалт тун сайтай, чулуу өрж, шаваасаар сайтар бэхлэн тогтоосон хийцтэй бөгөөд хаалгын гадуур дөрвөлжилсэн үүдэн далдавч хийсэн, сайтар бэхэлсэн байдалтай. Хэрмийн далан орчны газрын гадаргаас дээш 6 м, газрын хөрсөн дор 1

м байгаа гэх. Хаанаас ч харлаа гэсэн маш тод ялгаран мэдэгдэх ба малтсан хэсгийн зүсэлтээс үзэхэд дээд оройн хэсэг нь л бага сага нурж унаснаас бус хэрмийн суурь, дунд хэсгүүд тэр хэвээрээ хуучин чулуун өрлөгтэйгээ байх ажээ. Хэрмийн дотор олон орд барилгын үлдэгдэл маш хэлбэрээ тодорхой хадгалан үлджээ.

Дотор хотод буй нэгэн том ордны туурь дээр ирвэл энд түүхийн гурван үед холбогдох соёлт давхрага илт мэдэгдэх ажээ. Үүнд, хамгийн эртний Юан улсын үед холбогдох барилгын суурийн нэг буланг малтаж ил гаргасан нь дөрвөлжин баганын суурьтай, өнцөгт нь мод босгож тэмдэглэсэн байна. Үүний дараахи үед уг барилгын нурангийн дээр бас нэгэн барилгыг барьсан нь хэмжээгээр түрүүчийнхээс багавтар бөгөөд чулуугаар өрж хийсэн ханын үлдэгдэл дөрвөлжин хэлбэрээрээ байна. Энэ нь Мин улсын үеийнх гэнэ. Үүнээс хожуу Манж Чин улсын үед бас нэгэн барилга барьсаны чулуун хана хадгалагдан үлджээ. Энэ ордыг зарим эрдэмтэн Их Амгалан харш гэж үздэг гэнэ. Баганын дөрвөлжин суурь чулууг багвар чулуу гэдэг гэж Дуншиг гуай тайлбарлалаа.

Хотын хэрмийн зүүн хэсэгт малтан ил гаргасан хэсгийг сонирхон үзвэл 5-6 м орчим өндөртэй чулуун өрлөг ханан хэрэм, цонж цамхгийн суурь өргөссөн хэсэгтэйгээ байх ба энэ хэсгийн тавцан суурийн дээр нэгэн их мод ургасныг "Өвгөн хайлаас" хэмээн нэрлэнэ. Энэ модноос олон хадаг уяатай, хүмүүс энд ирж хүндэтгэл үзүүлэн тахил өргөдөг байна. Бид ч энд мөн бяцхан зан үйл гүйцэтгэж, тахил өргөн монгол хаадын дээд нийслэлдээ залбиран хэрмийн ханаас адис авч хадаг, монгол сархадын дээж өргөв.

5. Чулуун хөрөг

Шанд балгасын гадаад хэрмийн урдуур эртний энэ дурсгалыг тэмдэглэсэн том чулуун хаалга босгож хаяг хаджээ. Мөн бяцхан музей, бэлэг дурсгалын мухлаг зэрэг байх ба энд энэ орчмын нутгаас авчирсан хүн чулуудыг тусгай асар саравчид байрлуулсан байх ажээ. Эдгээрийг байрлалаар нь өмнөөс хойш дараалуулан бичвэл :

Зөөлөн голын Олон мод хэмээх газраас авчирсан бусадтай нь харьцуулахад нилээд болхи хийцтэй хүн чулуу. Үүнийг Дуншиг гуай Хүннүгийн үеийнх гэж тайлбарласан ба Шандаас урагш орших Бор балгас Хүннүгийн үеийн хотын ойр олноо газраас авчирчээ. Энэ нь толгой нь бүтэн боловч нүүр царайн дүрс

тодорхой бус, цээжинд нь хөх бололтой хоёр багавтар товгор мэдэгдэх ба гарыг дүрсэлсэн бололтой бага сага овгортой. Цээжнээс доош хэсэг мэдэгдэхгүй, ер нь бүрэн бус заримдаг, өөрөөр хэлбэл зөвхөн цээж хөрөг болой.

Мөн Зөөлөн голын Олон мод хэмээх газраас авчирсан нэгэн чулуун хөрөг буй нь дээрхээс 300 м орчим зайд байжээ. Энэ хүн чулууны онцлог нь ардаа ганц салаа урт гэзэгтэй, үүгээрээ Түрэгийн үеийн зарим хүн чулуутай төстэй.

Дараагийн хөрөг нь Хадан хошуу, Улаан гуу хэмээх газрынх. Түүний дараагийнх Шилийн хот явах замд байх Бурхантын хөндийн зүүнтээ Хар гуу, Улаан гуу хэмээх газраас олдсон гэнэ. Эдгээр хөргийн дүрслэл төдий л тодорхой бус, хадгалалт төдий л сайнгүй ч түшлэгтэй исэрт суусан байдал нь Монгол гүрний үеийн дурсгал болох нь мэдэгдэнэ.

Гурав дахь нь Бурхантын хөндий, Бумбан завсар, Хадан хошуу буюу Ян Чун Мяо гэдэг газраас олдсон тун уран хийцтэй гурван хөрөг байна. Эдгээрийг цайвар өнгийн гантиг чулуугаар урласан бөгөөд зөрүүлдэг хөлтэй, ардаа түшлэгтэй исэр суудалд залран суусан байдалтай. Манай Сүхбаатар аймгийн Онгон сумын Шивээт, Таван толгойд буй гайхамшигт уран хүн чулуудын ижил дурсгал ажээ. Хэдийгээр толгой нь салж алга болсон ч биеийн үлдсэн хэсэг тун сайн хадгалагдсан, сийлбэр дүрслэлүүд нь тун тодорхой мэдэгдэх ажээ. Хэрэв манай Таван толгойн хөрөгт луугийн дүрс мэдэгдэхээс бус чухам хэдэн хумстай нь тодорхой мэдэгддэггүй бол энд таван хумстай луугийн дүрс, өөрөөр хэлбэл эзэн хааны бэлгэ тэмдэг тодорхой харагдана. Энэ мэтчилэн нарийн ширийн бүхнийг нь судлан шинжигч хэмээвээс эдгээр хөргийг тусгайлан төсөл гаргаж тавтай нарийвчилж үзэх шаардлагатай, XIII-XIV зууны монголчуудад хамаарах туйлын үнэтэй дурсгал ажээ.

Эдгээр долоон хөргөөс гадна саравчны гадаа хэвтээ байгаа нэг хөрөг нь Олон мод хэмээх газрынх гэнэ.

Хөргүүдийг Дуншиг абугай өөрийн бичсэн номонд ерөнхийд нь дүрслэн тайлбарлаж нийтэлсэн ба тэрбээр хүн чулуутай холбоотой дараах зүйлийг өгүүлсэн юм.

Баруун Хойдын Үндэстний Их Сургуулийн нэг профессор Бээжин хотын орчим хадгалагдаж байгаа Юаны үеийн хоёр чулуун хөргийн зургийг нь сүүдэрлэн авч, Ланчжоу хотод тайлбар сэлт бүхий ном гаргаж байгаа гэнэ. Тэдгээрийн нэгийг

Елюй Чу Цайн хөрөг гэж үзэж байгаа ба нөгөөг нь Дээд нийслэлийн газрыг анх үзэж сонгосон Лю Бин Жун гэдэг хүнийх гэж үздэг гэнэ. Эдгээр хүний нэр ус нь тодорхой мэдэгддэг юм байна. Дээд нийслэл барих газрыг сонгосон хятад хүний нэрийг сонсоод бид шинжихэд монгол хүн, нутгийн ардууд оролцсон л байж таараа гэж өөр хоорондоо ярьж байв. Баяр доктор чулуун хөргүүдийг тун удаан анхааралтай үзэж, зургийг нь дахин дахин авч байгааг хараад бид гурав: “Чи эндээ үлдэж, хэд хоног ажилла. Эсвэл энд хүргэн ороод чулуун хөргүүдийг сайтар судла” гэж хошигнож байлаа.

Дуншиг гуайн ярьснаар Өвөр Монголд халхчууд нилээд оршин суудаг гэнэ. Тухайлбал, Ёгурын дотор цөөн халх бий. Баруун Цахарт дөрөв сум халх байдаг гэнэ. Жирэмийн чуулганд халх хошуу бий гэх ба энэ нь одоо Тунляо хот юм байна. Эд нар нь хожим, бараг XX зууны эхэн үед ирсэн хүмүүс юм. Улаанхадад буй Баарин, Жарууд зэрэг нь эртний Өвөр Халхын таван отгийнхон гэнэ. Хөх нуурт Цогт тайжийнхны үлдэгдэл халхчуудаас гадна сүүлд ирсэн цөөн халх бий аж.

Шулуун Хөх хошууны төвд нэгэн эмнэлгийн газраар орж тэндхийн ажил байдалтай танилцаж, эрүүл мэндийн талаар хувийн зөвлөлгөө авлаа. Тэнд Мөнх-Өлзий хэмээх нэг монгол эмч, бас нэг хятад эмч байсантай уулзаж Өвөр Монголын эмнэлэг, эмчлэх үйл ажиллагаа, эм ба эмчлэх үйл ажиллагааных нь талаар сонирхон ярилцсан болно.

7 дугаар сарын 5-ны нар хур тэгширсэн сайхан өдөр. Өчигдөр Пунсагтай уулзахаар ирсэн ангийн нөхөд, мөн хошууны удирдах ажилтан залуус болох Оюундалай, Мөнхбаатар зэрэг хүмүүс манай буурчийн газар цугларчээ. Пунсагийн коллежийн найз Хурцбилэгийнхний хөдөө гэрээр очиж нутгийн, эндхийн монголчуудын аж амьдралыг сонирхохоор хөдөө нутгийн зүг хөлгийн жолоог запав. Хэсэг давхиад Пунсагийн ангийн Нарангоо, нөхөр Банзрагчийн хамт, мөн ангийн Урантуяа, Хурцбилэг зэрэг хүмүүстэй аян замын дөрөө нийллээ.

Бидний очих газар нь хошууны төвөөс зүүн тийш 80 орчим км зайтай Эрдэнэ далайн зуслан хэмээнэ. Энэ нутгийн төрх Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур, Өвөрхангайн Бүрд зэрэг манайхны “шүдлэн говь” гэж нэрлэдэг сумуудтай тун төстэй юм. Бид Хурцбаатарын хот айлд хүрэлцэн ирэв. Тэр хот айлынхан хэд хэдэн монгол гэр барьсан байв. Зусландаа гэр барих бууриа бетон цутгаж хийсэн бөгөөд үүнийгээ тойруулан ширгээр манаж, гэрийн дотор хойт хэсгийг нийтэд нь

өндөрлөн дэвсгэр дэвссэн (манайхан наар засах гэж ярьдаг) нь олуул хэвтэж унтах, зэрэгцэн суухад нэн тохиромжтой. Бусад нь манай Монгол улсын хөдөө нутгийн эгэл айлтай ижил. Эхлээд биднийг цагаан идээ, хайлмаг, бяслаг (сүүн хурууд), чура (ээзгий) зэргээр дайлав.

Бид тэндээсээ холгүй байх Мухар булаг хэмээх элс манхантай, хайлаас мод ургасан, тал талаасаа 5 булаг цутган орж нийлдэг байгалийн үзэсгэлэнтэй газрыг үзэж сонирхов. Хустай, Нарстай гэх мэт олон булгуудын цутгалан аж.

Энд буй Хурцбилэгийн хамаатнуудын дотроос ахмад нь Хурцбаатар – 1956 онд төрсөн, дүү нь Мөнхөө, мөн тус гацааны намын дарга Цэвэл (тэд өөрсдөө Сээвэл гэж ярьдаг) зэрэг хүмүүс байдаг юм байна. Биднийг Мухар булгаас буцаж ирэхэд хонь гаргажээ. Эхлээд тураг махаар дайлаад, дараа нь таван цул өгч, шөл уулгав. Манайд бол арай өөр, эсрэг байдаг.

Энэ нутгийн хүмүүс мал маллан амьдрах ба энд суурьшсан зарим хятад хүн мал адуулахад сүрхий сайн суралцаж, гайгүй ажилладаг гэнэ. Тэд ахуй амьдралдаа монголын мал аж ахуйн үг хэллэгийг хэрэглэдэг, монгол аргаар л малаа малладаг юм байна. Ер нь энэ нутгийн монголчууд бүгдээр өөрийнхөө ахуй заншил, соёлоо хадгалж үлдэн, үр хүүхэддээ өвлүүлэх талаар их анхаарч санаа тавьдаг, төрөл бүрийн ажил зохиодог гэж ярьж байв. Нүүдлийн ба суурин соёл зөрчилдөөд тун амаргүй байдаг гэнэ. Соёлын хувьсгалын үед нилээд газарт хүчээр аму, хүнсний ногоо тариалж байжээ. 1980-аад оноос Өвөр Монголд тариалангийн газрыг буцааж малын билчээр болгох уриа гарч, үүнийг зохих ёсоор хэрэгжүүлжээ.

• Шулуун Хөх хошуу 80 гаруй мянган хүн амтай, үүнээс гучин долоон мянга нь монгол үндэстэн ажээ. Энд үндсэндээ адуу мал маш цөөн болсон, айраг исгээ гэхэд адуугүй болсон тул яах ч арга байдаггүй. Билчээр их сүйтгэдэг гэж адууг зориуд улсын бодлогоор цөөрүүлсэн юм байна. Монголчууд адуугүй болсондоо санаа их зовж эргэж адуугаа бага ч гэсэн өсгөж үржүүлэх, адууны соёлыг үр хүүхэддээ сургахын тул янз бүрийн арга хэмжээ, тухайлбал эмнэг сургах, морь уургалах, хурдан хүлгийн уралдаан тэргүүтнийг зохион байгуулж, адууны аж ахуйг сэргээх талаар хэр чадлаараа мэрийж байгаа гэнэ. Энэ сайхан тал нутгаа унаган төрхөөр нь авч үлдэхийн тулд ихээхэн хүчин зүтгэл гаргаж байгаа нь илт.

6. Элдэв сонин

Монгол утга соёлоо хөгжүүлж өвлүүлэх тал дээр их анхаардаг тухай Оюундалай их зүйл ярив. Монгол улсын шүлэгч, яруу найрагчдын зохиол бүтээлийг уйгуржин монгол бичигт хөрвүүлж нийтэлдэг, нэн ялангуяа Чойнямын зохиолыг бүрнээр хэвлэгдсэн нь залуусын дунд маш их газар авч түгсэн гэнэ. Гэхдээ энд бас анхаарууштай зүйл байгааг Оюундалай дурдахдаа, манай залуус Монголын орчин үеийн уран зохиол, яруу найргийн үндэс суурийг нь Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Б.Явуухулан мэтийн их хүмүүс тавьж өгсөн гэдгийг ойлгохгүй, зөвхөн Р.Чойнямаас өөр шүлэгчгүй юм шиг сэтгэж байгаа нь буруу гэж ярьж байна. Тэр тусмаа Чойням нь хөдөлмөрлөж суралцалгүйгээр архи уусаар зохиол бүтээл туурвиад байсан мэт буруу ойлголт бий гэв. Биднийг дагалдан явж үйлчилсэн Оюундалай билэг оюун тавирсан залуу сэхээтэн, Мөнхбаатар ончийг нь олж хошигнох дуртай, чадварлаг сайн зохион байгуулагч гэдгээ харуулсан юм.

Нутгийн монголчууд эх нутаг, түүх соёлоо аварч хамгаалахын төлөө анхаарсаар ирсний нэг тод жишээ нь 1958 онд Хятадын өмнө зүгийн мужаас өлсгөлөн зовлонд нэрвэгдэн дайжсан хэсэг өрх айл ирж, Хубилай хааны Шанд балгасын дотор орж зөвшөөрөлгүй суурьшчихаад гарч өгөхгүй байсан гэнэ. Үүний нутгийн олон дургүйцэж, монгол дарга нар ч ая эвийг нь олж хөөцөлдсөөр байж, тэдгээр хүмүүст байшин тосгон барьж өгч байж балгас дотроос гаргаж суулгасан гэнэ. Тэдэнд зориулж "5 дугаар сарын 1-ний малжлын талбай" гэдгийг байгуулж, үхэр тэжээлгэсэн юм байна.

Эндэх нутгийнхан гол төлөв цахар хүмүүс. Тэд олон овгоос бүрдэлтэй, Чингис хааны үеэс хишигтэн хэмээн нэрлэж байсан энд, тэндээс цугларсан эрэлхэг дайчдын удам угсаа бөгөөд Батмөнх Даян хааны үеэс "цавчих илдийн ир болсон цахар түмэн" гэж алдаршиж иржээ. Хожим манж нар Монголыг эрхшээлдээ оруулах үед цахарууд Лигдэн хааны удирдлагаар ихэд эсэргүүцэн тэмцсэн бүлгээ. Манж нар цахаруудыг тараан суулгаж, хүчийг нь сарниулж Шинжаан, Хар мөрөн зэрэг газарт суулгаж байсан гэдэг. Ингээд цахар түмнийг манжийн цэргийн засаг захиргааны хуваарь ёсоор 8 хошуу болгон хувааж, тугийнх нь өнгөөр нэрлэсэн бөгөөд энэхүү Шулуун цагаан хошуу бол эдгээр найман хошууны нэг болой.

Цахарын дотор олон овог ясны хүмүүс байх ба энд хэрэйд тун их гэнэ. Найман ч байдаг. Сартуул ч байдаг. Цахар нутгийн нэрт түүхч Сайшаал авгай сартууд баянбуу овгийн хүн юм. Бидэнтэй цуг явсан Дуншиг гуай мянгад овогтон гэнэ. Мөнхбаатар өөлд овогтой аж. Энд Галдан бошигт хааны өөлд нараас үлдсэн хоёр сум бий. Түүнчлэн Номтын Ринчин дагуулж очсон буриад нар ч байдаг юм байна.

Одоо Өвөр Монголд үг ярианы хувьд хамгийн голлож баримтлах аялгыг цахар аялгуугаар тогтоож, Шулуун Хөх хошууг гол болгон төв буюу баримжаа аялга гэж үздэг юм байна. Ер нь цахар бол Өвөр Монголын хамгийн гол төв нь болох учир нийтээр баримтлан ярихад бүгдэд ойлгомжтой дөхмийг бодсон хэрэг. Сөнөд, авга, үзэмчин нар цахарт хамаарах ба харин эдний хэл аялга халхтай илүү ойр, ялангуяа Сөнөд болоод Авгын зарим сум халхаас бараг ялгагдахгүй ярьдаг. Ийнхүү Шулуун хөх хошууны хөдөө нутгийн үзэсгэлэнг бахдаж, монгол заншлаа хадгалж үлдсэн элэг нэгт ах дүү нартайгаа цуг хааяа нэг сархад шимэн, ая өргөж, сэтгэл ханамжтайгаар цагийг өнгөрөөж байгаад, оройхон хошууны төвд ирж хоноглов.

7. Шандын шар тал минь, баяртай

Маргааш нь 7 дугаар сарын 6-ны өдөр хошууны удирдах нөхөд, хошууны намын хорооны орлогч Сэцэнчимэг биднийг үдэхээр цуг хөдөлж хотоос хөдөө гарч, мөнгөн аягатай сархад хадагтай барьсан үндсэний хувцастай гурван монгол охин ая барьж биднийг хүндэтгэн, дундад эртний монгол заншлаар ёслон үдлээ. Энд тэмдэглэхэд, нүдэнд нь инээмсэглэл тодорсон сайхан монгол бүсгүй Сэцэнчимэг дарга Монгол улсын ХААИС-ийн докторант юм байна. Тэрээр энэ хэд хоногт бидний аялалыг тохь тухтай, сонирхолтой болгоход үргэлж анхаарал тавьж байсныг талархан тэмдэглэх ёстой.

Тэндээс хөдөлж хэдэн цаг давхисаар Шилийн хотод ирэв. Эл хотноо түр саатаж, Өвөрмонголын алдарт яруу найрагч На.Сайнцогтын хөшөөний дэргэд гэрэл зураг татуулав. Мөн тэнд Чингис хааны хар сүлдийг 13 овоо босгож тахьсан түүх, соёлын цогцолборыг үзэж сонирхов. Шилийн хоттой зурвас төдий танилцахад ирээдүйн их хотын төрх сэтгэлд бууна.

Хотоос гарч, нэг хоёр цаг давхиад Авга цагаан хошууны нутаг болох нэлдээ хөмөл ургасан тал руу орж ирэв. Бид их хааны минь хишиг хэмээн бэлгэшээж, хүн

бүр бага сага хөмөл түүв. Бид цааш явсаар Эрээн хотноо ирж хоноглон, маргааш нь Эрээнээс хөдөлснөөр бидний аялал шувтрах тийшээ хандлаа.

Бидний хэсэг түүхчид гэхэд л дэлхийн өнцөг булан бүрт тарж бутарсан цөөн тооны угсаа нэгт ахан дүүсээ дутуу ойлгож явжээ. Өвөр Монголын өөртөө засах орны Шулуун хөх хошууны монголчууд л гэхэд олон зуун сая хан үндэстний дотор түүх, хэл, соёлоо чамгүй сайн хадгалан үлдсэнийг бие сэтгэлээр мэдэрлээ. Дэлхийн монголчууд бие биенээ дотночилж, уугуул гал голомтоо сахиж хоцорсон бидний монголчууд тэдэндээ сэтгэлийн дэм өгч, түүх, соёлын уламжлалаа өвлөн хадгалахад нь үлгэр жишээ болж байвал зүгээрсэн. “Үсэрсэн цус, тасарсан мах”, “Элэгний эмтэрхий, ясны хэлтэрхий” харь газар суурьшсан монголчууд мину !